

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагийн 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан

2022 оны 12 дугаар сарын 25

Мандалговь хот

### НЭГ.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ЯВЦ, ҮР ДҮН


Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагийн 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу агентлагуудаас ирүүлсэн тайланд үндэслэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах, үнэлэхэд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагуудыг харгалзан байгууллагын гүйцэтгэлийг үнэлэх арга зүйгээр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 24 агентлагаас 21 агентлаг гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтээ тайлагнасан. Цагдаагийн газар, Шүүхийн шинжилгээний алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар зэрэг агентлаг тайлангаа ирүүлээгүй учир үнэлгээ хийгдээгүй.

Нийт 21 агентлаг 176 зорилтын хүрээнд 801 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 93.5 хувийн дундаж үнэлгээтэйгээр хэрэгжүүлэн ажилласан нь өмнөх оны үнэлгээний дүнтэй харьцуулахад 1.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Үнэлгээний дүнгээс харахад Боловсрол, шинжлэх ухааны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Ус цаг уур орчны шинжилгээний төв, Мал эмнэлгийн газар, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газар, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг агентлагууд урд оноос үнэлгээний дүнг ахисан үзүүлэлттэй байна.

2022 оны үнэлгээний дүнг графикаар харуулбал:



Үнэлгээний дүнг агентлаг бүрээр 2021, 2022 оныг харьцуулан харуулбал:

№	Агентлагийн нэр	Зорилт		Арга хэмжээ		2022 оны	Зорилт		Арга хэмжээ		2021 он	өсөлт бууралт
		тоо	хувь	тоо	хувь		тоо	хувь	тоо	хувь		
1	БШУГ	3	89	31	95	92	8	92.6	40	90.1	91.3	
2	БОАЖГ	14	99.2	73	98.5	98.9	13	96.1	77	96.6	96.6	
3	Статистикийн хэлтэс	3	100	24	90.4	95.2		97.2		98.9	98	-2.8
4	ОНӨГ	6	91	23	91.3	91.2	2	100.0	11	95.0	97.5	-6.35
5	ГХБХБГ	13	100	43	99.8	99.9	10	98.3	33	100.0	99.1	
6	СХЗХэлтэс	7	89	29	83.5	86.3	12	96.6	23	93.0	94.8	-8.55
7	ХХҮГ	11	91	42	90.9	91.0	13	94.1	48	97.9	96	-5.05
8	НДХ	4	100	24	80.4	90.2	3	96.6	15	97.0	96.8	-6.6
9	ОБГ	4	100	36	92.7	96.4	4	100.0	31	96.3	98.1	-1.75
10	ТХ	10	99	50	91.6	95.3	7	96.4	32	96.8	96.6	-1.3
11	МХГ	14	100	46	95.6	97.8	11	100.0	29	96.5	98.2	-0.4
12	УЦУОШТ	15	92.6	54	99.7	96.2	13	92.3	43	93.0	92.7	
13	МЭГ	10	92.4	55	89.7	91.1	13	84.7	54	91.8	88.3	
14	СХДАА	5	99.8	13	92.1	96.0	5	90.0	22	92.3	91.5	
15	УБХ	9	95.5	45	96.6	96.1	9	91.2	64	95.1	93.1	
16	ГБХЗХГ	5	91.2	35	85.1	88.2	4	100.0	23	93.8	96.9	-8.75
17	ЭМГ	13	100	29	90.4	95.2	10	85.0	61	91.5	88.2	
18	БТСГ	3	100	46	91.5	95.8	3	96.7	33	87.9	92.3	
19	ХХААГ	16	89.8	48	87.9	88.9	16	95.6	43	90.8	93.2	-4.35
20	СУГ	6	95	40	95	95	0	0.0	0	0.0	0	0
21	ЭМДХэлтэс	5	80	15	93	86.5	0	0.0	0	0.0	0	0
22	Дүн	176	95.0	801	91.9	93.5	156	94.9	682	94.4	94.7	-1.2

**ХОЁР.ДУТАГДАЛТАЙ БОЛОН АНХААРАХ АСУУДАЛ**

Агентлагууд гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтуудтай уялдуулаагүй, 4 жилийн зорилтыг шууд хэрэглэж, шалгуур үзүүлэлтээ оновчтой тодорхойлоогүй, суурь түвшин, хүрэх түвшнийг суурь судалгаанд үндэслэж гаргаагүй, байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой зорилт, арга хэмжээг төлөвлөгөөгүй, тайлангийн чанар хангалтгүй, үг үсэг найруулга зүйн алдаатай, тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэх нь тодорхой бус байсан учраас тайланг 2-4 удаа буцаасан нь хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хүндрэлтэй байлаа.

Зарим нэг агентлаг зорилтыг хэрэгжүүлэхийн тулд зөвхөн 1 арга хэмжээ төлөвлөсөн байна.

**Цаашид анхаарах асуудал агентлаг бүрээр:**

№	Агентлагийн нэр	Тайлбар / зөвлөмж цаашид анхаарах асуудал/
1	БСУГ	Шалгуур үзүүлэлт хүрэх түвшингээ оновчтой тодорхойлж тайлангийн чанарт анхаарах Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа бодлогын баримт бичиг, сайдын гэрээ болон бусад төлөвлөгөөнүүдтэй уялдуулан төлөвлөж байх. Байгууллагын төлөвлөгөөнд орсон асуудлыг нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулж байх Цэцэрлэг хамран сургалт нь зорилтот түвшиндээ хүрээгүй учраас хувийг нэмэгдүүлэх

		Суурь боловсролын монгол хэлний хичээлийн аймгийн гүйцэтгэлийн дундаж хувь -63.2 байгаа нь зорилтот түвшиндээ хүрээгүй байна. Биеийн тамирын хичээлийн кабинетын тоо 8 нь зорилтот түвшиндээ хүрээгүй. UBT.mn цахим платформ нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх
2	БОАЖГ	Зарим нэг арга хэмжээ давхцаж төлөвлөгдсөн байсан.
3	Статистикийн хэлтэс	E-Mongolia төрийн үйлчилгээний программын хэрэглээ ашиглалтыг нэмэгдүүлэх Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх тал дээр хүрэх түвшиндээ хүргэж мод тариагүй.
4	ОНӨГ	Албан хаагчдыг жилд 1-ээс доошгүй удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж нарийн мэргэжлийн үзлэг шинжилгээ хийлгэх, шаардлагатай ажилтнуудыг тухай бүрд эмчилгээ сувилгаа хийлгэх витаминжуулалтад хамруулах зэрэг эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх гэсэн арга хэмжээ хүрэх түвшиндээ хүрээгүй. Төлөвлөгөөг журмын дагуу боловсруулах
5	ГХБХБГ	
6	СХЗХэлтэс	Төлөвлөлт хангалтгүй тайлангийн чанар муу, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаандаа тайлагнаагүй хугацаа хоцроосон. зорилт болон хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой төлөвлөгөөгүй, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин нь шаардлага хангаагүй. 1 зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг 2-оос доошгүй байхаар төлөвлөх Даралт, масс, эзлэхүүн, цахилгааны 3073 хэмжих хэрэгсэлд шалгалт баталгаажуулалт хийх зорилтын хэрэгжилт зорилтот түвшиндээ хүрээгүй.
7	ХХҮГ	Цалин хөлсний үзлэг зохион байгуулах ажил жил бүр тасарч байна. Хөдөлмөрийн аюулгүй байдал хангагдаагүйгээс үйлдвэрлэлийн осол 5 гарсан учраас зөвлөл болон ажил хариуцсан нэгжийн ажлыг сайжруулах, ХАБЭА-н орон нутгийн зөвлөлийн гишүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, Гадаадын төсөл хөтөлбөрүүдэд төсөл бичиж, хэрэгжүүлэх, Цалин хөлсний үзлэгийг зөвхөн НДХ-ээс ирүүлсэн судалгаанд үндэслэн хийсэн байгаа нь төдийлөн хангалттай биш байна. Жил бүр 12 сард хийхээр төлөвлөж байна гэдэг тайлан ирдэг байсан үүнд онцгойлон анхаарах Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа бодлогын баримт бичиг, сайдын гэрээ болон бусад төлөвлөгөөнүүдтэй уялдуулан төлөвлөж байх / 1 арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, хүрэх түвшин зарим нэг арга хэмжээн дээр өөр байна. Байгууллагын төлөвлөгөөнд орсон асуудлыг нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулж байх. Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хяналт шинжилгээ үнэлгээний нэгжээр үнэлүүлж байх
8	НДХ	Төлөвлөлтийн чанарыг сайжруулах, зорилтдоо чиглэсэн арга хэмжээг төлөвлөх Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа бодлогын баримт бичиг, сайдын гэрээ болон бусад төлөвлөгөөнүүдтэй уялдуулан төлөвлөж байх Гадаадын хөрөнгө оруулалтаар төсөл хөтөлбөр санхүүжүүлэгч байгууллагуудад нэг болон түүнээс дээш тооны төсөл бичиж хүргүүлэх ажил тасарсан Байгаль орчин ногоон бүсийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд тодорхой бүсэд мод тарьж ургуулсан байх Сайн дурын даатгалд иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулж хамралтыг нэмэгдүүлэх гэсэн арга хэмжээнүүд хүрэх түвшиндээ хүрээгүй.
9	ОБГ	
10	ТХ	Татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь тэр дундаа илүү их тасардаг орлогын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг дараа оны төлөвлөгөөнд тусган хэрэгжилт үр дүнг тооцож байх. Албан хаагчдын чадавхжуулах хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралтаар батлагддаг сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээндээ оруулж төлөвлөх "Гэрэгэ" киоск машин байршуулах, Талбай хуваарилан авч зүлэгжүүлэх, Албанд ТЕГ-с баталсан зураг төсвийн дагуу шинэ байрны төсвийг 2023 онд төсөвт суулгах ажил тасарсан.
11	МХГ	"Тогтвор суурьшилтай боловсон хүчин үйл ажиллагаа" Төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, байр орон сууцны дэмжлэгт хамрагдах Аймгийн ЗДТГ-аас хэрэгжүүлж буй хяналт шинжилгээ, үнэлгээний цогц системийн талаар 2022 онд 2 албан хаагчийг сургалтад хамруулах гэсэн 2 арга хэмжээ тасарсан байна.
12	УЦУОШТ	Зарим нэг суурь түвшин түрүү оны хүрсэн түвшингээс өөр байгаа учир суурь түвшинд анхаарах, "Цаг уурын үйлчилгээ иргэн бүрд" зорилтын хүрээнд сумдад нээлттэй хаалганы өдөрлөг, зохион байгуулсан арга хэмжээг 6 удаа гэж төлөвлөсөн боловч 1 удаа онлайнаар зохион байгуулсан нь зорилтот түвшиндээ хүрээгүй учир 0 үнэлгээ авсан. Цаг уур, орчны шинжилгээний хэмжлийн нэгдмэл байдлыг хангах гэсэн зорилт нь хүрсэн түвшин нь суурь түвшин зорилтот түвшингээсээ бага учир 0 үнэлгээ гарсан.
13	МЭГ	Зооноз өвчнөөс нийтийн эрүүл мэндийг хамгаалах хамтарсан салбар зөвлөл"-ийн үйл ажиллагааг сайжруулах, Мал эмнэлгийн магадлан шинжилгээний гэрчилгээ олгох ажлын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, Хээлтүүлэгч малд бруцеллээс өвчин илрүүлэх тандалт шинжилгээ хийх, Мах, сүүнд эмийн үлдэгдлийн шинжилгээ хийх арга хэмжээ нь зорилтот түвшиндээ хүрээгүй учир тасарсан тул 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх
14	СХАА	Санхүүгийн зөрчилтэй их дунд эрсдэлтэй байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргаж тоог хэрхэн бууруулж байгаа нь тодорхойгүй байна.

15	УБХ	Үг үсгийн алдаа их, тайлангийн найруулга муу, шалгуур үзүүлэлтээ оновчтой тодорхойлоогүй байсан нь үнэлгээ өгөхөд хүндрэлтэй байсан. Төлөвлөлтийн чанар хангалтгүй. Шалгуур үзүүлэлт хүрэх түвшингээ оновчтой тодорхойлж тайлангийн чанарт анхаарах, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 тушаалаар батлагдсан аргачлалыг уншиж судлан төлөвлөлт, тайлагналтын нийтлэг болон тусгай шаардлагыг хангаж, Тоон гарын үсэг олгох арга хэмжээ хүрэх түвшиндээ хүрээгүй. Ажлыг эрчимжүүлэх. Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаа эрчимжүүлэн ёс зүйн зөрчлийг бууруулах, хүчингүй болгож байгаа үнэт цаас их байгаа учир албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх
16	ГБХЗХГ	Цахим орчноор дамжуулан залуучуудад сургалт нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах, Залуучуудад тулгарах асуудал, бэрхшээлийг даван туулах чадамж, залуучуудын бие бялдар оюун санаа сэтгэлгээ, ур чадварын харилцаанд ахиц өөрчлөлт өгөх цогц үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрээгүй. Сумдын Залуучуудын хөгжлийн зөвлөлөөр дамжуулан малчин залуучуудын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх "Илгээлтийн эзэн" аян, уулзалт зохион байгуулах
17	ЭМГ	Төлөвлөлт тайлангийн чанар маш сайн. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх, Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай өрхийн эзлэх хувийг нэмэгдүүлэх, Өрх, сумын эрүүл мэндийн төвд 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэгийг зохион байгуулах арга хэмжээнүүд зорилтот түвшиндээ хүрээгүй.
18	БТСГ	Шилэн дансанд төсвийн гүйцэтгэлийн мэдээг хуулийн хугацаанд байршуулж хэвшээд байна. Нийт 133 мэдээллээс хөрөнгө оруулалт тендер, худалдан авалттай холбоотой 24 мэдээлэл, төсөв гүйцэтгэлтэй холбоотой 22 бусад 87 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж иргэдийг мэдээллээр хангаж ажилласан.2/6 хоцроосон. Байгууллагын хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн журмын дагуу аймгийн архивд 8 хадгаламжийн нэгж шилжүүлэн ажилласан нь хүрэх түвшиндээ хүрээгүй.
19	ХХААГ	Зорилтоо бодлогын баримт бичгийн зорилтод тулгуурлан оновчтой тодорхойлон зорилтын хүрээнд хийх ажлыг чанартай сайн төлөвлөж байх, зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд давхацсан. Тайланг Хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан албан хаагч бодитой үнэлгээ хийх тал дээр дутагдалтай. Тайлангийн чанар хангалтгүй, үг үсгийн алдаа их байна. Малыг ялган тэмдэглэж, бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн дэд системүүдэд баяжилт хийх арга хэмжээ зорилтот түвшиндээ хүрээгүй. Үржлийн хээлтүүлэгч бух, ухна, хуцыг удам зүйн үнэлгээний программд бүртгэх арга хэмжээний хүрээнд Удам зүйн үнэлгээний программын шинэчлэгдэж байгаа тул малын бүртгэл хийгдээгүй байна учир тасарсан. Дэлхийн банкны санхүүжилттэй МААЭЗЭН төслөөр санхүүжүүлж айргийн лабораторийн судалгааны ажлыг хийхээр төлөвлөсөн боловч УИХ-аас 2022 оны 04 сарын 29-ны өдрийн Төрийн хэмнэлтийн тухай хууль гарсантай холбогдуулан санхүүжилтийн ажил зогссон тул лабораторийн судалгааны ажил түр хойшлогдоод байна.
20	СУГ	Соёл, урлагийн байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулах зорилт зорилтот түвшиндээ хүрээгүй Соёл урлагийн салбарын байгууллагуудыг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах арга хэмжээний хэрэгжилт удаашралтай. Салбарын стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх арга хэмжээ гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт тайлагнаснаас хойш батлагдсан.
21	ЭМДХэлтэс	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг ЗГ-ын 2020 оны 217, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 тушаалаар батлагдсан аргачлалын дагуу боловсруулах Төлөвлөгөө болон тайлангийн чанар хангалтгүй байна. Тайланг 2000 тэмдэгтэд багтаан үр дүн талаас нь тайлагнах. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 2021 онд 2,5 тэрбум төгрөг төвлөрүүлж биелэлт 100,7%. 2022 онд эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг 90 хувиас доошгүй биелүүлнэ гэсэн зорилтын хэрэгжилт 54 хувьтай.

## ГУРАВ.ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам", Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын дагуу нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан төлөвлөлт хийх

Гүйцэтгэлийн тайлан нь иж бүрэн, алдаа мадаггүй, бодитой, итгэл үнэмшил төрүүлэхүйц, аль болох товч тодорхой, нэг арга хэмжээний гүйцэтгэлийг 2000

тэмдэгтэд багтаан ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэх, хүрээгүй бол шалтгаан нөхцөлийг тодорхой дурдах гэсэн нийтлэг болон тусгай шаардлагуудыг хангасан байхаар тайлагнах

Хяналт шинжилгээ, үнэлгээг үнэлгээний аргачлал, арга зүйгээр хийж байхаас гадна хяналт шинжилгээ, үнэлгээний хагас бүтэн жилийн тайланг байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаараа хэлэлцүүлж, хурлаас гарсан дүгнэлт зөвлөмжийг нэгж албан тушаалтанд хүргүүлэн биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулж байх


Мөн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дотоод ажилтай холбоотой зорилт арга хэмжээг төлөвлөөгүй нийтлэг дутагдал байгаа учир Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд төлөвлөн хэрэгжүүлж байх / захиргаа, хүний нөөц, төсөв санхүү, хууль, эрх зүй, хяналт шинжилгээ үнэлгээ, авлига, архив албан хэрэг хөтлөлт, иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлт шийдвэрлэлт, гэх мэт/

Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг арга хэмжээ тус бүрээр нарийвчлан тусгаж, хэрэгжилтийг тайлагнахдаа зарцуулсан төсвөө зайлшгүй бичиж байх /байгууллагын өөрийн нөөц бололцоог ашиглан хэрэгжүүлж болохуйц зорилт, арга хэмжээ биш гэдгийг ойлгох хэрэгтэй/


Түрүү жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс хэрэгжээгүй буюу тасарсан арга хэмжээг 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллах

Цаашид анхаарах нийтлэг зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтийн хамт тайланг гэрээнд заагдсан хугацаанд ирүүлэх

Тайлан хянасан

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн даргын  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  Д.Даариймаа

Тайлан бичсэн

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн  
ахлах мэргэжилтэн  Э.Одончимэг

